



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/29

Чингис хот

Баримт бичиг нягтлан шалгах
комиссыг шинэчлэн томилж, ажиллах
журмыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Архивын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт, Үндэсний архивын газрын даргын 2007 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 59 дүгээр тушаалаар батлагдсан "Байгууллагын архивын ажлын үндсэн заавар"-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын дэргэд баримт бичгийн үнэ цэнийг тогтоох, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг шалган зааварлах үүрэгтэй баримт бичиг нягтлан шалгах комисс томилж, комиссын ажиллах журмыг хавсралтаар баталсугай. Үүнд:

Комиссын дарга: -Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүдэд: -Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

-Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн хүний нөөцийн удирдлага, агентлаг хариуцсан мэргэжилтэн

-Нийгмийн бодлогын хэлтсийн соёлын үйл ажиллагаа, биеийн тамир спортын бодлого хариуцсан мэргэжилтэн

-Санхүү төрийн сангийн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн

-Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Худалдаа үйлчилгээ, хүнс, аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга

-Архив бичиг хэргийн эрхлэгч

2. Архив, албан хэрэг хөтлөлтийн холбогдолтой хууль, дүрэм, заавар, тогтоолуудыг ажилдаа мөрдлөг болгож ажиллахыг комиссын даргад даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР